



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/370

Арвайхээр

**Шууд гэрээ байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2. дахь заалтыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 09/10 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 1.8 тусгагдсан (Нийтийн орон сууцны засвар, дээврийн засвар) эх үүсвэрээс Арвайхээр сумын 5 болон 13 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах 153, 212, 454, 190, 191, 192, 343, 345, 351, 353, 355, 356 дугаар байрнуудын усны хаялгын засварт 8.000.000 (найман сая) төгрөг зарцуулж, “ОНГИ-ӨРГӨӨ” Сууц өмчлөгчдийн холбоотой гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100596